



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/113

Мандалговь


┌ Өвс, тэжээлийн тусламж үзүүлэх тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр дугаар зүйлийн 29.1.3 “а”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр байгаль цаг агаарын аюултай гамшгийн эрсдэлийн болон гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлын хүрээнд хавсралтад дурдсан тоо хэмжээгээр сумдад өвс тэжээлийг Мал хамгаалах сангаас үнэгүй олгосугай.

2. Дээр дурдсан өвс, тэжээлийг татан авах, хүргэх ажлыг яаралтай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тайлан тооцоог хийж бүртгэлд тусгахыг Ерөнхий санхүүч (С.Энхжаргал), Сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210324